



ТЭНГЭР ДААТГАЛ ХК-ИЙН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН
(2026 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар)

Тэнгэр Даатгал ХК нь 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хооронд олон нийтэд нэгж бүр нь 800 төгрөгийн үнэтэй 12,500 ширхэг энгийн хувьцааг санал болгож, нийт 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгийн хөрөнгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Тэнгэр Даатгал ХК нь энгийн хувьцааг олон нийтэд санал болгон арилжсанаар өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, татан төвлөрүүлсэн хөрөнгийг эргэлтэд оруулан ашигт ажиллагаагаа дэмжин ажиллаж байна. Мөн өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор цахим шилжилтийг хэрэгжүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа хадгалах, тэлэх стратегийг хэрэгжүүлж байна.

Түүнчлэн ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн BR 25/003 болон 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн BR 26/04 дугаар тогтоолуудын дагуу 2024 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 67.12 төгрөг (нийт 4,027,200,000 төгрөг), 2025 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 114.4 төгрөг (нийт 6,864,000,000 төгрөг)-ийн ногдол ашгийг тус тус хуваарилан олгосон.

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг дараах хүснэгт №1-т төгрөгөөр илэрхийлэн харуулав.

Хүснэгт №1 Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

№	Зарцуулалтын төрөл	Эзлэх хувь	Нийт дүн	Зарцуулалтын дүн
1	Борлуулалт дэмжих хөрөнгө оруулалт	48%	4,800,000,000	4,800,000,000
2	Бусад хөрөнгө оруулалт	21.6%	2,160,000,000	2,160,000,000
3	Сунгалтын систем болон аппликейшн хөгжүүлэлт	8%	800,000,000	800,000,000
4	Харилцагчдын санхүүгийн боловсролыг дэмжих маркетинг	2.4%	240,000,000	Ажил хийгдэж байна
5	"Мандал праявит экүити хувийн ХОС" ХХК-ийн 2,500,000 ширхэг энгийн хувьцааны төлбөр	20%	2,000,000,000	2,000,000,000
Нийт		100.0%	10,000,000,000	9,760,000,000

- Тэнгэр Даатгал ХК нь 2024 оны 11 дүгээр сард Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлснээс хойш банк болон банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, нийт 4,800,000,000 төгрөгийн хадгаламж, итгэлцлийн хөрөнгийг байршуулсан нь борлуулалтыг дэмжих ач холбогдолтой байна.
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн 21.6 хувийг хувьцаа гаргалттай холбоотой болон үйл ажиллагаа, хүний нөөцийн зардалд зарцуулж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор даатгал, санхүүгийн ERP системийн хөгжүүлэлтэд 800,000,000 төгрөгийг төсөвлөсөн.
- Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд харилцагчдын санхүүгийн боловсролыг дэмжих маркетингийн аян болон Онцгой байдлын байгууллагатай хамтран зорилтот бүлгийн сургалтад зарцуулан ажиллаж байна.
- Түүнчлэн "Мандал Прайвит Экүити Хувийн ХОС" ХХК-ийн эзэмшиж байсан 2,500,000 ширхэг энгийн хувьцаанд хамаарах 2,000,000,000 төгрөгийн хувьцааг буцаан худалдан авсан болно.